



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



"ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН"

сэдэв аудитын тайлангаас:



01

ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ
АЙМГИЙН 2021–2025 ОНЫ
ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД
ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ.



02

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ
**ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН
БАЙГУУЛААГҮЙ.**



03

САНХҮҮЖИЛТИЙГ
**БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН
ОЛГООГҮЙ БАЙНА.**



Дээрх асуудлууд нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж, **төсвийн хөрөнгийн үр ашиг, хариуцлагыг** бууруулах эрсдэлтэй байна.



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” **сэдэв аудитын тайлангаас:**

1



Худалдан авах ажиллагааны төлөвлөлт тодорхойгүй, үнэлгээний хороо байгуулах болон захиалагчаас хүсэлтийг хугацаа алдаж хүргүүлсэн зэргээс шалтгаалан нийт зохион байгуулсан худалдан авах ажиллагааны **31.3%**-ийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулж дуусгаагүй.

2



Үнэлгээний хороод тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй **41 оролцогчийг** гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан.

3



Үнэлгээний хорооны гишүүд, сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагч нарт тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийг хянан үзэх, үнэлэх зэрэг мэргэжил арга, зүйн зөвлөгөөгөөр хангаж, үүрэг хариуцлагыг идэвхжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэл, хяналтад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж, ил тод, хариуцлагатай, үр ашигтай хэрэгжилтийг хангах нь иргэдийн эрх ашгийг хамгаалах, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл юм.





ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” **сэдэв аудитын тайлангаас:**

АУДИТААР НИЙТ

14,028.7 САЯ ТӨГРӨГИЙН
ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЖ



7.7

САЯ ТӨГРӨГИЙН

2 зөрчилд
төлбөрийн акт
тогтоов.



13,250.2

САЯ ТӨГРӨГИЙН

зөрчлийг арилгах
41 албан шаардлага
өгөв.



770.8

САЯ ТӨГРӨГИЙН

зөрчлийг давтан
гаргуулахгүй байх
30 заалт зөвлөмжийг
холбогдох байгууллага,
албан тушаалтнуудад
хүргүүлэв.



Аудитын дүнгээр илэрсэн зөрчлүүдийг арилгах, давтан гаргуулахгүй байхад анхаарч, хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

